



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 15 өдөр

Дугаар A/234

Арвайхээр


Тэндериин гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2019 оны 4 дүгээр сарын 15-ний өдрийн 32 дугаар зөвлөмжийн дагуу улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих Сургуулийн барилга, 320 суудал /Өвөрхангай, Хархорин сум/ барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах (БСШУСЯ/201902053)-ийг 3199793552 (гурван тэрбум нэг зуун ерэн есөн сая долоон зуун ерэн гурван мянга таван зуун тавин хоёр) төгрөгөөр Химон констракшн ХХК -иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.
3. Шалгарсан гүйцэтгэгч аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД



011100539